



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 1622

Мандалговь

Г Эрх бүхий төлөөллийг томилох тухай 7

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын журам"-ын 4.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн болон орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгөөр хийгдэх барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл, худалдан авах тоног төхөөрөмжийн актанд гарын үсэг зурах захиалагчийн төлөөллөөр дараах албан тушаалтнуудыг томилсугай. Үүнд:

-Барилга угсралт болон засварын ажилд:


- Аймгийн ЗДТГ-ын дарга
- ХОХБТХ-ийн дарга
- Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
- ГХБХБГ-ын дарга
- ХОХБИХ-ийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
- ГХБХБГ-аас томилогдсон хяналтын инженер
- Ашиглагч байгууллагын дарга, эрхлэгч

-Худалдан авсан тоног төхөөрөмжийн ажилд:

- Ашиглагч байгууллагын дарга эрхлэгч нарын тушаалаар батлагдсан комиссын гишүүд

Хоёр. Барилга угсралт болон их засварын ажилд байнгын хяналт тавьж норм, норматив, дүрэм болон батлагдсан ажлын зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон ажлын төлөвлөгөөг үндэслэн гарын үсэг зурж баталгаажуулахыг дээрх эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



0200592